



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 8/42

Шивээговь сум

С.Энхтайвантай байгуулсан хөдөлмөрийн
гэрээг цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, 110 дугаар зүйлийн 110.3, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/191 дугаар “Журам батлах тухай” тушаалын хавсралт “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”-ын 1.1, 2.8.1 дэхь заалт, ажилтантай байгуулсан хөдөлмөрийн гэрээг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1.Засаг даргын Тамгын газрын Хогны машины жолооч Санжсүрэнгийн Энхтайван нь өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ ирүүлсэн тул хөдөлмөрийн гэрээг 2022 оны 06 дугаар сарын 02-ны өдрөөс цуцалсугай.

2.С.Энхтайваны хариуцаж байсан ажлыг хүлээлцэх комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Комиссын дарга:

Д.Сэлэнгээ
(Нягтлан бодогч)

Гишүүд:

Д.Отгонбаатар
(Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Б.Алтжин
(Нярав)

3.С.Энхтайвантай холбогдох тооцоог хийж дуусгахыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д үүрэг болгосугай.

4.С.Энхтайванд ажилласан хугацааны амралтын мөнгийг бодож олгохыг нягтлан бодогч (Д.Сэлэнгээ)-д зөвшөөрсүгэй.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ЦЭРЭНДОРЖ



D:\2022 oni barimt\TDarga\tushaal

42222 172